



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ADB ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ.....	2
---------------------------	---

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж	5
Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар	11
2.1 Үнэлгээний даалгавар	11
2.2 Үнэлгээний жишиг даалгаврын хувилбар	12
Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал	19
Дөрөв. Анхаарах зүйл, санамж	21

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

Энэхүү зөвлөмжөөр Мэдээллийн технологийн хичээлийн цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтод тулгуурлан суралцахуйн үр дүнг тодорхойлж, түүнд үндэслэн боловсруулсан үнэлгээний шалгуурыг хэрхэн хэрэгжүүлэх арга зүйг танилцуулж байна.

Мэдээллийн технологийн хичээлээр сурагчийн эзэмших мэдлэг, чадвар суралцахуйн зорилтуудыг анги тус бүрд “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үндсэн ойлголт, Мэдээлэл боловсруулах технологийн хэрэглээ” гэсэн үндсэн хоёр агуулгын чиглэлийн хүрээнд 8 бүлэг сэдвээр ангилж, залгамж холбоог тусган боловсруулсан (Хүснэгт 1).


Хүснэгт 1. Агуулгын чиглэл бүхий бүлэг сэдэв (Суралцахуйн удирдамж, 2019)

Бүлэг сэдэв	VI анги	VII анги	VIII анги	IX анги
Мэдээ, мэдээлэл	+	+	+	+
Компьютер	+	+	+	+
Үйлдлийн дараалал			+	+
Бичиг баримт боловсруулах технологи	+	+	+	+
Зурган мэдээлэл боловсруулах технологи	+	+	+	+
Танилцуулга боловсруулах технологи		+	+	
Хүснэгтэн мэдээлэл боловсруулах технологи			+	+
Цахим харилцаа, интернэт технологи	+	+	+	+

Агуулгын дээрх чиглэлийг үндэслэн суралцахуйн үр дүнг 8 бүлэг сэдвээр нэгжийг багцлан тодорхойлсон.

Зөвлөмжийн хүрээнд 6-р ангийн “Баримт бичиг боловсруулах технологи” нэгжийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх жишээ авч үзлээ.

Бүдүүвч 1. Суралцахуйн зорилт, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшингийн хамаарал



Бүдүүвч 1-ийн а)-д Мэдээллийн технологи хичээлийн суурь боловсролын хөтөлбөрт 6-р ангийн “Баримт бичиг боловсруулах технологи” бүлэг сэдэв нь 6.3.а, 6.3.б, 6.3.в гэсэн суралцахуйн зорилт тодорхойлогдсон байна. Эдгээр суралцахуйн зорилтыг хэрэгжүүлснээр б)-д буй хоёр суралцахуйн үр дүнд хүрнэ. Тодорхойлсон суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхийг в) дэх үнэлгээний шалгуурт нийцсэн даалгавраар шалгаж тогтооно. Үнэлгээний шалгуурт тусгагдсан мэдлэг, чадварыг ямар түвшинд эзэмшсэнийг г) дэх гүйцэтгэлийн түвшинээр тогтооно гэдгийг томьёолон харуулсан болно.

Суралцахуйн зорилт

Суралцахуйн зорилт бол суралцагчийн эзэмших чадварын илэрхийлэл юм.

Дараах хүснэгтэд суралцахуйн зорилтыг томьёолоход ашигласан аргачлалыг тайлбарлаж харууллаа (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Суралцахуйн зорилтыг тайлбарласан байдал

СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ	ТӨРХ БАЙДАЛ, ГҮЙЦЭТГЭЛ Сурагчид юуг хийж, бүтээж чаддаг болох вэ?	НӨХЦӨЛ Мэдлэг чадвараа хэрхэн харуулах вэ?	ШАЛГУУР Ямар шалгуураар сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг харуулах вэ?
6.3а. Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж, компьютерт догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган оруулах	Бичвэр мэдээллийг компьютерт оруулах	Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж	Догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган
6.3б. Баримт бичиг боловсруулах программ ашиглан гарын хурууны зөв байрлалаар бичих технологиор бичвэр мэдээллийг компьютерт оруулах	Бичвэр мэдээллийг компьютерт оруулах	Баримт бичиг боловсруулах програм ашиглан	Гарын хурууны зөв байрлалаар бичих технологиор
6.3в. Баримт бичигт тавигдах шаардлагад нийцүүлэн үсгийн хэлбэр, хэмжээ, өнгө, мөр зэрэгцүүлэх командаар бичвэрийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх	Бичвэрийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх	Баримт бичигт тавигдах шаардлагад нийцүүлэн	Үсгийн хэлбэр, хэмжээ, өнгө, мөр зэрэгцүүлэх командаар

Суралцахуйн зорилтын төрх байдал буюу гүйцэтгэл нь энэ зорилтыг хэрэгжүүлснээр юуг хийж, бүтээж чаддаг болох вэ? нөхцөл нь эзэмшсэн мэдлэг чадвараа ямар орчин нөхцөлд харуулах вэ? шалгуур нь сурагчийн эзэмшсэн мэдлэг чадварыг ямар шалгуураар харуулах вэ? гэдгийг илэрхийлж байдаг.

Суралцахуйн үр дүн

Суралцахуйн үр дүн (СҮД)-гийн талаар дараах ойлголтыг авч үзлээ.

Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хичээлийг амжилттай дуусгахад, хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай суралцахуйн амжилтыг тодорхойлох тусгай илэрхийлэл.

Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хичээлийг судалж дууссаны дараа харуулж чаддаг болох ёстой тусгай төрх байдал (behaviours)-ыг тодорхойлдог.

Сурагчийн суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрөөр суралцаж дүүргэсний дараа сурагчийн хүлээсэн мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагад чиглэсэн байх ёстой.

Хүснэгт 3. Суралцахуйн үр дүнгийн “ABCD” арга

A	Сонсогч / Audience	Хэн	СҮД хэнд хандсан бэ?
B	Төрх байдал / Behaviour	Юу	Сурагчид юуг мэддэг, чаддаг болно гэж хүлээж байна вэ? Идэвхтэй үйл үгээр илэрхийлнэ.
C	Нөхцөл / Condition	Хэрхэн	Ямар нөхцөл байдалд, хязгаарлалтад сургалтыг явуулах вэ?
D	Degree	Хэр зэрэг	Төрх байдлыг хэр зэрэг /хэр сайн/ ямар түвшинд гүйцэтгэсэн байх вэ?

Энэхүү аргачлалыг ашигласан суралцахуйн үр дүнг авч үзье (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Суралцахуйн үр дүнг томъёолсон байдал

СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН	СОНСОГЧ Хэн	ТӨРХ БАЙДАЛ, ГҮЙЦЭТГЭЛ Юу	НӨХЦӨЛ Хэрхэн	ТҮВШИН Хэр зэрэг
Сурагч бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар хурдан, алдаагүй оруулж чаддаг болно.	Сурагч	Бичвэр мэдээллийг оруулж чаддаг болно.	гарын хурууны зөв байрлалаар	хурдан, алдаагүй
Сурагч бичвэр мэдээллийг хэлбэржүүлэлт, мөр зэрэгцүүлэлт хийх замаар баримт бичгийн шаардлагад нийцүүлэн боловсруулж чаддаг болно.		Бичвэр мэдээллийг боловсруулж чаддаг болно.	хэлбэржүүлэлт, мөр зэрэгцүүлэлт хийх замаар	баримт бичгийн шаардлагад нийцүүлэн

Эндээс суралцахуйн үр дүнгээр төрх байдал, гүйцэтгэл нь сурагч юуг мэддэг, чаддаг болсон байх вэ?, нөхцөл нь хэрхэн, ямар нөхцөл хязгаарлалтад, ямар арга замаар, Түвшин (Degree) нь хэр зэрэг түвшинд эзэмших вэ гэдгийг илэрхийлж байна. Дээрх жишээнд сурагчийн чаддаг болох зүйл нь “Бичвэр мэдээллийг оруулж чаддаг болно”. Гэхдээ бичвэрийг гарын хурууны зөв байрлалаар бичих технологиор оруулдаг болно гэсэн нөхцөл тавьж байна. Энэ чадварыг ямар түвшинд эзэмших вэ? гэвэл хурдан, алдаагүй бичиж оруулдаг болох ёстой болж байна.

Ийнхүү тухайн суралцахуйн зорилт, үр дүнг задалж ойлгох нь түүнд харгалзах үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшнийг тусгасан даалгавар боловсруулахад чиглэл болж өгнө.

Үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуур нь сургалтын үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн.

Үнэлгээний шалгуур нь суралцагчийн хүрсэн үр дүн, амжилтыг илэрхийлэх бөгөөд шалгуур, гүйцэтгэлийн үзүүлэлт гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Шалгуур нь суралцагчдын “Би юу хийх ёстой вэ?”, гүйцэтгэлийн үзүүлэлт нь “Би яаж хийх ёстой вэ?” гэсэн асуултад хариулна.

Үнэлгээний шалгуур нь СҮД-д хүрсэн амжилтыг харуулахын тулд сурагчид юу хийх ёстойг ойлгомжтой болгохоос гадна багш нарт сурагчдын амжилт, гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх хүчин зүйлсийг тодорхойлно.

Хүснэгт 5. СҮД ба үнэлгээний шалгуурын хамаарал

Нэгж	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
Баримт бичиг боловсруулах технолог	6.3а	Сурагч бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар хурдан, алдаагүй оруулж чаддаг болно.	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг
	6.3б	Сурагч бичвэр мэдээллийг хэлбэржүүлэлт, мөр зэрэгцүүлэлт хийх замаар баримт бичгийн шаардлагад нийцүүлэн боловсруулж чаддаг болно.	Компьютерт гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг тайлбарладаг.
			Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулдаг.
	6.3в	Сурагч бичвэр мэдээллийг хэлбэржүүлэлт, мөр зэрэгцүүлэлт хийх замаар баримт бичгийн шаардлагад нийцүүлэн боловсруулж чаддаг болно.	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг тайлбарладаг.
			Бичвэр мэдээллийг боловсруулахдаа хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг.

Хүснэгт 5-д эхний СҮД-д хүрсэн гэдгийг харуулахын тулд бичвэр мэдээллийг бүрдүүлэгч хэсгүүдийг мэддэг, гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг ойлгосон, бичих арга техникээ мэдэж тайлбарлаж чаддаг болсон байхаас гадна түүнийг ашиглан бичвэр мэдээллийг компьютерт оруулдаг болсон байхыг харуулж байна.

Гүйцэтгэлийн түвшин

Үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн үзүүлэлтийг гүйцэтгэлийн 4 түвшнээр тодорхойлсон. Үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлохдоо ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам¹-ыг үндэслэн боловсруулсан.

Үнэлгээний журамд:

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. “Шалгуурт суурилсан үнэлгээ” нь суралцагчийн амжилтын түвшинд хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд 8 түвшинтэй байна гэж заасан байна.

¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралт

Үнэлгээний журамд тусгасан 8 түвшний шалгуурд үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлж гаргасан (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Үр дүнгийн үнэлгээний түвшин, шалгуур

Түвшин	Үнэлгээний түвшний шалгуур
I-II	<input type="checkbox"/> Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таньдаг, нэрлэдэг, цээжилдэг. <input type="checkbox"/> Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг.
III-IV	<input type="checkbox"/> Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг тайлбарладаг, бүрэн ойлгодог. <input type="checkbox"/> Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг. <input type="checkbox"/> Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлдэг, шинжлэн судлах үйлд оролцдог. <input type="checkbox"/> Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. <input type="checkbox"/> Асуудал, мэдээллийг эргэцүүлэн боддог, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг. <input type="checkbox"/> Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг.
V-VI	<input type="checkbox"/> Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгодог. <input type="checkbox"/> Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг, танил нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг. <input type="checkbox"/> Таамаглал/асуудал, асуулт/дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөхөд оролцдог, төлөвлөдөг. <input type="checkbox"/> Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг. <input type="checkbox"/> Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, гол санааг илэрхийлдэг.
VII-VIII	<input type="checkbox"/> Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтол, хоорондын хамаарлыг бүрэн ойлгодог, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарладаг, тодорхойлдог, үнэлэлт дүгнэлт өгдөг, санал гаргадаг. <input type="checkbox"/> Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг. <input type="checkbox"/> Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг. <input type="checkbox"/> Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг. <input type="checkbox"/> Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг.

Хүснэгт 6 дахь үнэлгээний түвшний шалгуурыг багцалж үзвэл: Үнэлгээний түвшин бүрд

1. Шинжлэх ухааны мэдлэгийг хэрхэн ойлгож тайлбарлах
2. Мэдлэгээ хэрхэн, ямар нөхцөлд хэрэглэх
3. Асуудлыг ямар аргаар, ямар хэмжээнд шийдвэрлэхийг ялган тодорхойлсон байгааг өнгөөр ялган тэмдэглэв.

Түвшин бүрд тусгасан түлхүүр үгийг баримжаалан тухайн үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлсон байдлыг хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт 7. “Баримт бичиг боловсруулах технологи” нэгжийн үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшин

СҮД шалгуур	СҮД-ИЙН ШАЛГУУР ДАХЬ СУРАГЧИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж, тайлбарладаг	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялгаж, компьютер хэрхэн ойлгодог болохыг тайлбарладаг	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган оруулах хэрэгцээ, шаардлагыг тайлбарладаг	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар зөв оруулсан байдлыг тайлбарладаг
Компьютерт гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг тайлбарладаг	Гарын үндсэн байрлал дахь үсгүүдийг (й ы б ө р о л д) тайлбарладаг	Гарын үндсэн байрлалаар хэрхэн бичих аргыг тайлбарладаг	Гарын үндсэн байрлалд тулгуурлан бусад үсгүүдийг бичих зүй тогтлыг тайлбарладаг	Компьютерын гарын хурууны зөв байрлалаар бичих технологийн давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг
Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулдаг	Компьютерт бичвэр мэдээллийг тайлбар зураг болон гарын товчлуурыг харж оруулдаг	Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар удаан оруулдаг	Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар бичих технологийн шаардлагыг баримталж оруулдаг	Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар шаардлагын дагуу хурдан, алдаагүй оруулдаг
Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг тайлбарладаг	Хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг өөрийн үгээр тайлбарладаг	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг жишээгээр тайлбарладаг	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг хэрэгцээ, шаардлагатай нь холбон тайлбарладаг	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг баримт бичигт тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг
Бичвэр мэдээллийг боловсруулахдаа хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг	Хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг зааврын дагуу гүйцэтгэдэг	Баримтын гарчиг, үндсэн хэсэгт хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг	Баримтын гарчиг, үндсэн болон онцлох хэсэгт хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг зорилготойгоор гүйцэтгэдэг	Баримт бичигт тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлд нийцүүлэн хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

Мэдээллийн технологи хичээлийн сургалтын үйл ажиллагаанд оношлох (гарааны), явцын, үр дүнгийн (эцсийн) үнэлгээ хийгдэнэ.

2.1 ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

6-р ангийн “Баримт бичиг боловсруулах технологи” нэгж хичээлийн хүрээнд мэдээллийн технологийн цөм хөтөлбөр дэх үнэлгээний зорилт, үнэлгээний шалгуур, суралцахуйн зорилтод үндэслэн ээлжит хичээл тус бүрээр дараах байдлаар (жишээгээр) үнэлгээний төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх боломжтой (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Нэгж хичээлийн үнэлгээний төлөвлөлт

№	Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур	Шалгуур код*	Суралцахуйн зорилт	Ээлжит хичээлийн сэдэв	Үнэлгээний төрөл, хийх арга	
						Явцын	Үр дүнгийн
1	А.Мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь мэдлэг, ойлголт	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарлах.	A1	6.3.а.б	Компьютер бичвэр мэдээллийг хэрхэн ойлгодог вэ?	<ul style="list-style-type: none"> Дасгал, даалгаварын гүйцэтгэлээр хийх үнэлгээний хуудас ашиглах 	Сорилоор үнэлэх 40%
		Компьютерт гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг тайлбарлах	A1, A5		Гарын хурууны зөв байрлалаар бичих		
		Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг тайлбарлах	A2, A4	6.3.в	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх		

2	Б.Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх	Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулах	Б3	6.3.а.б	Гарын хурууны зөв байрлалаар бичих	Дасгал, даалгаварын гүйцэтгэлээр үнэлэх, үнэлгээний хуудас ашиглах	Үнэлгээний шалгуурт үндэслэн даалгавар боловсруулах, дүгнэх аргачлал бэлтгэх 60%
		Бичвэр мэдээллийг боловсруулахдаа хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэх	Б4	6.3.в	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх		
3	В. Хандлага	Баримт бичиг боловсруулахад сул зай, цэг, таслал, хаалт, хашилт, зураас, догол мөрийг үүрэг зориулалтын дагуу зөв хэрэглэх	В1	6.3.а	Компьютер бичвэр мэдээллийг хэрхэн ойлгодог вэ?	Ажиглалт тэмдэглэл хөтлөх Үнэлгээний хуудас ашиглах	Үр дүнг сурагч бүрд танилцуулж зөвлөгөө өгөх АУБ нар, эцэг эхэд үнэлгээг танилцуулах
		Гарын хурууны зөв байрлалаар бичихдээ товчлуур харахгүй, дэлгэц рүү харж технологийн дагуу алдаагүй зөв, хурдан бичих	В2, В4	6.3.б	Гарын хурууны зөв байрлалаар бичих		
		Бичвэрийг баримт бичиг боловсруулах соёл, шаардлагад нийцүүлж хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх дадал, хэвшилтэй болох	В1, В2, В4	6.3.а.в	Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх		

* Шалгуур код - Суурь боловсролын “Мэдээллийн технологи” хичээлийн хөтөлбөр, үнэлгээний шалгуурын кодыг үзэх

2.2 ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ДААЛГАВРЫН ХУВИЛБАР

НЭГ. ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ

Оношлох үнэлгээ суралцагчийн өмнөх төсөөлөл болон мэдлэг чадварын түвшнийг тандах, суралцагчдад юу хэрэгтэй байгааг илрүүлэх зорилготой.

“Баримт бичиг боловсруулах технологи” нэгж хичээлийн оношлох үнэлгээний даалгаврын хувилбар (6-р анги)

1. Дараах жагсаалтаас өөрт тохирох хариултуудыг сонгоно уу.

- Би гэртээ компьютертой.
- Надад мэдээллийн технологийн сурах бичиг байгаа.
- Би компьютер асааж, программ дуудаж чадна.
- Би компьютерт бичвэр мэдээлэл оруулж үзсэн.
- Компьютерын гарын товчлууруудын үүргийг мэднэ.
- Кирил 35 үсэг гарын товчуурт хаана байрладгийг мэднэ.

2. Сурах бичгийн 22-р хуудасны Чадахуй: Дасгал 1-ийг хийгээд, дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

А. Дараах товчлууруудын үүргийг зөв харгалзуулна уу.

Товчлуур	Үүрэг
1. Caps Lock	a. Курсорын өмнө байрлаж байгаа тэмдэгтийг устгах
2. Space	b. Үсгийг томоор бичих
3. Enter	c. Хоосон зай авах
4. Backspace	d. Шинэ мөр үүсгэх
5. Delete	e. Догол мөр үүсгэх, курсорын байршил шилжүүлэх
6. Tab	f. Бусад товчлууртай хослон хэрэглэж, тодорхой үйлдэл гүйцэтгэх
7. Shift, Ctrl, Alt	g. Курсорын ард байрлаж байгаа тэмдэгт эсвэл сонгосон зүйлийг устгах

Түлхүүр: 1b, 2c, 3d, 4a, 5g, 6e, 7f

Б. Дараах тэмдэгтүүдийг ямар товчлуурын хослолоор бичих вэ? Жишээ: \$ - [Shift]+[4]

% - [.....]+[.....]	* - [.....]+[.....]	: - [.....]+[.....]
(- [.....]+[.....]	? - [.....]+[.....]	, - [.....]+[.....]
@ - [.....]+[.....]	“ - [.....]+[.....]	> - [.....]+[.....]

Түлхүүр:

% - [Shift]+[5]	* - [Shift]+[8]	: - [Shift]+[;]
(- [Shift]+[9]	? - [Shift]+[/]	< - [Shift]+[,]
@ - [Shift]+[2]	“ - [Shift]+[']	> - [Shift]+[.]

3. Бичвэр боловсруулах программыг ажиллуулах дарааллыг бичээрэй.

.....

4. Би монгол хэлний хичээлээр дараах зүйлийг мэддэг болсон. Тохирох үгийг нөхөж бичнэ үү.

- 1) Үгийг дэвтэр дээр бичихдээ үгнүүдийг хооронд нь тусгаарлана.
- 2) Нэг өгүүлбэрийг нөгөө өгүүлбэрээс ялгаж ойлгодог.
- 3) Цогцолбор: Сурах бичиг, уран зохиолын номд нэгэн ижил утга санааг илэрхийлэхэд гол төлөв мөрөөс эхэлж бичдэг. Үүнийг цогцолбор (зүйл) гэж нэрлэдэг.

Түлхүүр: 1) зайгаар, 2) цэгээр, 3) догол

Энэхүү даалгавараар тухайн суралцагч 6-р ангийн баримт бичиг боловсруулах технологи сэдвийг судлахад монгол хэлний хичээлийн үг, өгүүлбэр, цогцолбор, мэдээллийн технологи хичээлийн компьютер бүлэг сэдвийг судалж мэдсэн гарын товчлуурын үүрэг, хэрэглэх арга, программ дуудах, файл хадгалах зэрэг өмнөх суурь мэдлэг төсөөлөл, чадвар, суралцах технологийн орчин ямар байгааг илэрүүлэх зорилгоор оношлох үнэлгээг хийнэ гэж үзсэн.

ХОЁР. ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ

Явцын үнэлгээг сургалтын явцад хийдэг бөгөөд тухайн ээлжит хичээлийн суралцахуйн зорилт хэрхэн биелэгдэж, суралцагчид суралцахуйн үр дүнд хүрсэн эсэх гэх мэт сургалтын үйл ажиллагааг тодорхойлох, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилготой.

Ажлын хуудас

Анги: 6-р анги

Хугацаа: 40 мин

Нэгж хичээл: Баримт бичиг боловсруулах технологи

Ээлжит хичээл: Компьютер бичвэр мэдээллийг хэрхэн ойлгодог вэ?

Асуудал: Үг, өгүүлбэр, цогцолборыг компьютер хэрхэн ойлгодог вэ?

(Мэдээллийн технологи VI сурах бичиг, 2020 он, хуудас 24-25)

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	Үнэлгээний шалгуур
6.3а. Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж, компьютерт догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган оруулах	Суралцагч бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар хурдан, алдаагүй оруулж чаддаг болно.	6.3.1 Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.

1. Сурах бичгийн 25-р хуудасны ойлгохуй, мэдэхүйг уншаад, дараах өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.
Компьютер өгүүлбэрийг, үгийг, цогцолборыг гэж ойлгодог.

Явцын үнэлгээний даалгавар 1 (ЯҮД1), шалгуур: А1: III-IV Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж, тайлбарладаг.

2. Сурах бичгийн 25-р хуудасны анхаарахуйг ойлгож уншаад цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

- Компьютер ашиглан бичвэр бичихдээ:
- 1) Үг бүрийн дараа авна.
 - 2) Цэг, таслалыг өмнөх үгтэй бичээд, ард нь нэг авна.
 - 3) Өгүүлбэрийн дараа заавал тавьж, авна.
 - 4) Хаалт, хашилт нээгээд зай бичнэ. Хаалтан доторх өгүүлбэрт тавихгүй бичнэ.
 - 5) Зураас авсан тохиолдолд хоёр талд нь зай бичнэ.
 - 6) Цогцолборыг догол мөрнөөс эхлэх бол гарын товчлуурыг дарна.

Явцын үнэлгээний даалгавар 2 шалгуур: В1:V-VI: Баримт бичиг боловсруулахад “Сул зай, цэг, таслал, хаалт, хашилт, зураас, догол мөрийг үүрэг зориулалтын дагуу зөв хэрэглэх хэвшилтэй болох”

3. Дараах эхийг (Сурах бичгийн 34-р хуудасны хэрэглэхүйн даалгавар 2) компьютерт оруулахдаа өмнөх даалгаварт бичсэн санамжийн хэд дэхийг зөрчсөн болохыг илрүүлж тэмдэглээрэй.

Явцын үнэлгээний даалгавар 3 шалгуур: Б3:VI-VII: Бичвэр мэдээллийг догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган зөв оруулах

4. Бичвэр мэдээллийг боловсруулахдаа үг, өгүүлбэр, цогцолборыг ялган оруулах хэрэгцээ, шаардлагыг илэрхийлсэн өгүүлбэрийг сонгоно уу?

- Цогцолбор нь шинэ утга санаа эхэлж байгааг илэрхийлдэг.
- Өгүүлбэрт ижил төстэй утга илэрхийлсэн хэсэг оруулахад таслалыг хэрэглэдэг.
- Үгийг хооронд нь сул зайгаар тусгаарлана.

Явцын үнэлгээний даалгавар 4 шалгуур: В1: V-VI шалгуур: Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган оруулах хэрэгцээ, шаардлагыг ойлгосон

Энэ жишээнд ээлжит хичээлийн явцад суралцахуйн зорилтыг

1) 5)

Мазаалайн биеийн дундаж жин 90 - 100 килограмм, биеийн урт нь 150 сантиметр орчим, өндөр нь 80-92 сантиметр. Эрдэмтдийн судалгаагаар мазаалай 10 хүртэл насалдаг гэдгийг тогтоосон байдаг. арваннэгдүгээр сараас дараа жилийн гуравдугаар сар хүртэл агуй, хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур нүхэн хэвтэр засажичдэг амьтан.

хэрэгжүүлж, суралцахуйн үр дүнд хүрэхэд чиглэсэн дөрвөн үйл ажиллагаа буюу даалгавруудыг гүйцэтгэх явцад явцын үнэлгээг цогц байдлаар хийж болох ажлын хуудсыг авч үзлээ. Хичээлийн үр дүнг суралцагч бүрийн ЯҮД-ын гүйцэтгэлийг дараах амжилтын шалгуур хуудсаар өөрийн үнэлгээ, чацуутны буюу найз нөхдийн үнэлгээ байдлаар хийж болно. Ингэснээр суралцагч бүр өөрийн амжилтад дүгнэлт хийж даалгавруудаа бүрэн гүйцэд хийж, ээлжит хичээлийн зорилгоо ухамсарлан хоцрогдолгүй суралцах боломж олгож болох юм.

Амжилтын шалгуур (Чи хичээлийнхээ зорилго, зорилтыг хэрхэн биелүүлсэн бэ?)

Хүснэгт 9. Ээлжит хичээлийн явцын үнэлгээ

Шалгуур Үнэлгээ	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.			
	Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялгаж, тодорхойлсон (ЯҮД 1)	Баримт бичиг боловсруулахад сул зай, цэг, таслал, хаалт, хашилт, зураас, догол мөрийг үүрэг зориулалтын дагуу хэрхэн зөв хэрэглэх ёстойг мэдсэн (ЯҮД 2)	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган оруулах хэрэгцээ, шаардлагыг ойлгосон (ЯҮД 3)	Бичвэр мэдээллийг догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган оруулах аргыг ойлгосон (ЯҮД 4)
	3 оноо	6 оноо	3 оноо	6 оноо
Өөрийн үнэлгээ				
Хөндлөнгийн үнэлгээ				
Нийт оноо				

Нийт 18 оноо авахаас . . . оноо авсан.

Нийт 18 оноо авна гэж тооцоод үнэлгээг бодно. 18-ыг 100% гэж тооцоход 15 оноо авбал $15 \cdot 100 / 18 = 83.3\%$ үнэлгээ гарна. Жич: Хөндлөнгийн үнэлгээ гэдэгт багш, ангийн найз, гэр бүлийн гишүүд байж болно. Иймд нийт оноонд эдгээр үнэлгээний дунджийг тооцно.

Энд ээлжит хичээл бүрээр үнэлгээний шалгуурт үндэслэн боловсруулсан даалгаврыг гүйцэтгэж, гүйцэтгэлийг амжилтын шалгуураар үнэлж болох хувилбарыг авч үзлээ.


ГУРАВ. ҮР ДҮН (НЭГЖ СЭДЭВ)-ИЙН ҮНЭЛГЭЭ

Үр дүнгийн үнэлгээ нь суралцагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Үнэлгээний шалгуурыг хангаж буй эсэхийг үр дүнгийн үнэлгээгээр тодорхойлно. Үнэлгээ хийх хугацаа, арга хэлбэрээс үл хамаарч үр дүнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь нь тухайн суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг илэрхийлнэ.

Тодорхой зорилгын хүрээнд буюу бүлэг сэдэв, хагас болон жилийн эцсийн үр дүнгийн үнэлгээг бюпринтийн дагуу боловсруулсан шалгалтын материал /сорил, даалгавар, бие даалт, биечлэн гүйцэтгэх даалгавар, бүтээл, судалгаа, тайлан гэх мэт/-аар үнэлж, дүгнэхэд гарч буй үр дүн буюу гүйцэтгэлийн хувь нь тухайн суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлно. Энэ нь суралцагч тухайн түвшний шалгуурыг хангаж буй эсэхийг хянахад дэмжлэг болно.

Бүдүүвч 2. Мэдлэг, чадвар, хэрэглээний хамаарал



Бүдүүвч 2-ыг үр дүнгийн үнэлгээний даалгавар боловсруулахад тухайн нэгж сэдвийн хүрээнд эзэмшсэн байх, мэдлэг чадвар, хэрэглээг тодорхойлж, шалгалтын сэдэв зохиоход ашиглаж болно.

Хүснэгт 8-д төлөвлөсний дагуу бүлэг сэдвийн үр дүнгийн шалгалтын сэдэв А, Б хоёр хэсэгтэй бөгөөд А хэсэгт мэдлэг ойлголтыг шалгах нөхөх, сонгох даалгавар бүхий 11 сорил, Б хэсэгт компьютероор гүйцэтгэх суралцагчийн чадварыг илрүүлэх хэрэглээний интеграци задгай даалгаврыг орууллаа.

“Баримт бичиг боловсруулах технологи” сэдвийн үнэлгээний даалгавар

А. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн суурь мэдлэг, ойлголт (40%)

1. Эхийг ажиглан, өгүүлбэрийг гүйцээж нөхөж бичнэ үү.

Дараах эхэд 2 цогцолбор, 2 догол мөр байна. Эхний өгүүлбэрт 6 үг байна. Эхийн сүүлийн өгүүлбэрийн доогуур зурсан байна. (4 оноо)

Найз
Маш сайхан нөхөрлөдөг хоёр найз байжээ. Нэг нь маш зальтай зоригтой дайчин их хөдөлгөөнтэй. Харин нөгөө найз нь маш гэнэн шударга үг яриа цөөнтэй нэгэн байв. Гэтэл нэгэн өдөр овжин зальтай найз нь нөгөө найз дээрээ очоод өөрийнх нь хийж байсан ажил амжилтгүй болоод дампуурсан тухайгаа ярьж түүнээс мөнгө гуйжээ. Гэнэн цагахан найз нь түүний энэ хэцүү байдлыг ойлгон хадгаламжид байсан бүх мөнгөө түүнд өгөв. Найз нь ч өгсөн мөнгийг нь авч ажлаа дахин шинээр эхлээд урьдынхаасаа ч илүү ашигтай амжилттай ажиллав.
Хэсэг хугацааны дараа өнөөх сэргэлэн найз нь ирээд түүний гэрлэхээр сүй тавьсан бүсгүй өөрт нь маш их таалагддаг талаар хэлээд найз бүсгүйгээ өгөхийг гуйжээ. Залуу маш их гайхан юу ч гэж хэлэхээ мэдсэнгүй. Гэвч тэдний хооронд маш нандин үерхэл байсан учраас үгүй гэж хэлэлгүй хайрт бүсгүйгээ өгчээ...

2. Тохирох үгийг нөхөж бичнэ үү.

Үг бүрийн дараа нэг сул зай, өгүүлбэрийн дараа (цэг) тавьж нэг сул зай авна. Хаалт доторх өгүүлбэрт цэг тавихгүй. Зураас авсан тохиолдолд хоёр талд нь зай авахгүй, хашилт, хаалт нээгээд зай авахгүй бичнэ. Өгүүлбэрийг шинэ мөрөөс эхлэхдээ Enter товчийг дарж мөр шилжүүлнэ. Догол авах бол Tab товчийг дарна. (8 оноо)

3. Алдааг олж зурна уу. (5 оноо)

Мазаалай нь зөвхөн Монголын говь цөлд амьдардаг дэлхийд цор ганц баавгай, улаан номд орсон амьтан юм (<http://www.mazaalai.org>), 1960-аад онд 15-20 толгой, 1970-аад оны дундуур 20 гаруй, 1980-аад оны сүүлээр 50-60, 1990-ээд оны эхээр 30 гаруй, 2013 онд 22 толгой болсон байна.

4. Гарын үндсэн байрлалд ордог үсгүүдийг сонгоно уу. (3 оноо)

- А Х Б Т И У Д П Й

5. Гарын хурууны зөв байрлалаас дараах үйлдлийг хийхэд ямар үсэг бичигдэх вэ? (5 оноо)

Зүүн гарын долоовор хуруу баруун шилжиж дарах	а	Баруун гарын чигчий хуруу баруун шилжиж дарах	п
Зүүн гарын ядам хуруу доошоо шилжиж дарах	ч	Баруун гарын долоовор хуруу дээшээ шилжиж дарах	г
Зүүн гарын чигчий хуруу дээшээ шилжиж дарах	ф	Зүүн гарын долоовор хуруу доошоо шилжиж дарах	я

6. Гарын хурууны зөв байрлалаар кирил үсгийг бичихэд тавигдах шаардлагыг илэрхийлэх өгүүлбэрүүдийг сонгоно уу. (5 оноо)

- Хуруунууд үндсэн байрлалын үсгийн харгалзах товч дээр ямагт байрлах бөгөөд өөр үсэг дарахад буцаад байрандаа шилжинэ.
- Компьютерын гарыг харж бичнэ.
- Дэлгэц рүү харж бичнэ.
- Аль гарын ямар хуруунд ямар үсэг харгалзах, хэрхэн шилжиж дарахыг тогтоож, мөрдөх
- Гарын дасгал тогтмол хийх
- Алдаагүй, хурдан бичих
- Зөв суух

7. Бичвэр мэдээллийг боловсруулахад хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэхийн хэрэгцээ, ач холбогдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийг сонгоно уу. (4 оноо)

- Эмх цэгцтэй харагдана.
- Баримт бичиг боловсруулах шаардлагад нийцүүлнэ.
- Бичвэр мэдээллийн утга санааг тодруулна.
- Эхийн гарчиг, гол утга санаа, тоочимж, хүүрнэмжийг ялгахад тустай.


8. Баримт бичиг боловсруулах программаар бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх үйлдлийн дарааллыг бичнэ үү. (2 оноо)

- 1) Хэлбэржүүлэх бичвэрийг [сонгож тэмдэглэнэ \(идэвхжүүлнэ\)](#)
- 2) [Home](#) цэсийн [Font](#) бүлгийн командаас сонгоно.

9. Дараах өгүүлбэрийн цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичнэ үү.

Бичвэрийн хэсгийг идэвхжүүлэхдээ тухайн хэсгийн өмнө [хулганын заагчийг](#) байрлуулаад чирнэ. Үгийг идэвхжүүлэхдээ үг дээр хулганаар [хурдан хоёр](#) товшино. Бүгдийг сонгох бол гарын [Ctrl,+ A](#) товчлуурыг хосолж дарна. (3 оноо)

10. Дараах зурагт тэмдэглэсэн командын хэрэгслийн нэр, үүргийг дугаартай нь харгалзуулж хүснэгтэд бичнэ үү. (8 оноо)



Дугаар	Нэр	Үүрэг
1	Font	Үсгийн хэлбэр (фонт) сонгох
2	Bold	тодруулах
3	Italic	Үсгийг тодруулах
4	Underline	Үсгийг тодруулах
5	Font Color	Үсгийг тодруулах
6	Align Left	Мөрийг зүүн буюу урд талд зэрэгцүүлэх
7	Align Center	Мөрийг төвд буюу голд зэрэгцүүлэх

8	Align Right	Мөрийг баруун буюу хойд талд зэрэгцүүлэх
9	Justify	Мөрийг хоёр талд зэрэгцүүлэх
10	Font size	Үсгийн хэмжээг сонгох

11. Мөр зэрэгцүүлэх командууд аль бүлэгт багтах вэ? (1 оноо)

A. *Font* Б. *Paragraph*

Даалгаврын зөв хариулт, задгай даалгаврын зөв хариултын санааг цэнхэр өнгөөр ялгаж тэмдэглэв. А хэсгийн даалгаврын оноожуулалтыг нэг зөв хариулт тус бүр 1 оноо гэсэн байдлаар тооцож болно.

Б. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх (60%)

1). Дараах эхийг баримт бичиг боловсруулах программ ашиглан гарын хурууны зөв байрлалаар arial фонтоор, 11 хэмжээтэй бичиж, shargachin_6buleg_ner (жишээ нь: shargachin_6a_Temuulen) нэр өгч хадгалаарай.

Ч.Лодойдамба: “Шаргачин”
 Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж, өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гараад хэдхэн хоносон цайвар цагаан янзага дагуулсан шаргачин орж ирлээ. ... Уураг нь дуусаагүй өөг сүүндээ гэдэс нь цадсанаас ч юм уу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юм уу? Аль зуу зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу? Бүү мэд. Юу ч гэсэн дэрсэнд орсны дараа удалгүй янзага нь нуугдан унтав...

- 2). Эхийн утга санаанд нийцүүлэн цогцолбороор нь ялгаж, шинэ мөрнөөс, догол үүсгээрэй.
- 3). Гарчгийг том үсгээр, тод, цэнхэр өнгөтэй, зохиогчийн нэрийг тод, налуу, доогуур зураарай.
- 4). Эхийг бичиг хэргийн шаардлагад нийцүүлэн хэлбэржүүлж, мөрийг зэрэгцүүлээрэй.

(60 оноо)

Б хэсгийн даалгаврын гүйцэтгэлийг хүснэгт 10-ын шалгуур үзүүлэлт ашиглан үнэлнэ.

Хүснэгт 10. Даалгаврын гүйцэтгэл

Шалгуур	Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулдаг.						Бичвэр мэдээллийг боловсруулахдаа хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг.								
	Эх бичих						Баримт бичгийн шаардлагад нийцүүлэн бичвэрийг хэлбэржүүлэх			мөр зэрэгцүүлэх					
	ГХЗБ-аар бичсэн	Бүрэн бичсэн	Алдаагүй бичсэн	Сул зай, цэг, таслал зэргийг ашиглан бичвэрийг бүрдүүлэгч хэсгүүдийг зөв ялгаж оруулсан	Эхийг цогцолбор утгаар нь ялгаж оруулсан	Файлаа хадгалсан	Үсгийн фронт зөв сонгосон	Үсгийн хэмжээ тохируулсан	Шаардлагатай үг, өгүүлбэрийг ялгаж тодруулсан	Шаардлагатай үг, өгүүлбэрийг ялгаж, налуу болгосон	Шаардлагатай үг, өгүүлбэрийг ялгаж, доогуур зурж бичсэн	Гарчиг голлуулсан	Зохиогчийн нэрийг мөрийн хойд талд зэрэгцүүлсэн	Эхийн үндсэн хэсгийг мөрийн 2 талд зэрэгцүүлсэн	
Авах оноо	10	10	10	10	2	2	2	2	2	2	2	2	2	2	
Авсан оноо															

14 шалгуур нийт 60 оноотой. Даалгаврын оноожуулалт нь даалгаврыг гүйцэтгэх явцад хийх үйлдлийн цар хүрээ, зарцуулах хугацаа, шаардагдах чадвар зэргийг тооцож ялгаатай оноог авахаар хийсэн. А (40%), Б (60%) хэсэг дэх гүйцэтгэлийн нийлбэрээр нэгж сэдвийн үр дүнгийн үнэлгээ түвшин тодорхойлогдоно.

Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Шалгалтын дараа суралцагчдын гүйцэтгэлд шинжилгээ хийх, даалгавар тус бүрийн хүнд хөнгөний зэрэг болон ялгах чадвар, тохироц, хамаарал зэргийг нэг бүрчлэн авч үзсэнээр нэг талаас сайн даалгаврын сан үүсгэх нөгөө талаас багш ээлжит хичээлийг хэрхэн заасан талаарх мэдээллийг суралцагчдын гүйцэтгэлийн мэдээллээс авч болно.²

Бүлэг сэдвийн шалгалтын гүйцэтгэлд анализ хийхдээ 11-р хүснэгт дэх загварыг ашиглаж болно.

Үнэлгээний даалгавар зохиох, даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийх, үр дүнгийн хэрэглээний талаар “Бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэгжүүлэх зөвлөмж” (15-21-р хуудас)-д дэлгэрэнгүй тайлбарласан болно.

² Боловсролын үнэлгээний төв, 2020, “Боловсролын үнэлгээн, арга зүйн зөвлөмж”

Хүснэгт 11. Нэгж хичээлийн үр дүнгийн үнэлгээний анализ

Даалгаврын хэсэг	А										Б									
	1-10										11-20									
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
Даалгаврын дугаар	Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.										Компьютерт гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг тайлбарладаг.									
Шалгуур	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.										Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулдаг.									
Үзүүлэлт	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган олуулах аргыг тайлбарладаг.				Таньдаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
Сурагчдын нэрс	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган олуулах аргыг тайлбарладаг.				Таньдаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
Онгоо	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган олуулах аргыг тайлбарладаг.				Таньдаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
1 Сурагч 1	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
2 Сурагч 2	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
3 Сурагч 3	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
п Сурагч п	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
Авах оноо	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
Авсан оноо	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			
Гүйцэтгэлийн хувь	Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг.				Хэрхэн бичих аргыг тайлбарладаг.				Давуу тал, тавигдах шаардлагыг тайлбарладаг.				Хэрхэн, шаардлагатай нь холбоно тайлбарладаг.				Үндэслэл гүйцэтгэх арга, тавигдах шаардлага, мэдээлэл боловсруулах соёлтой холбож тайлбарладаг.			

Энэхүү даалгавараар тухайн суралцагч 6-р ангийн баримт бичиг боловсруулах технологи судлахад монгол хэлний хичээлийн үг, өгүүлбэр, цогцолбор, мэдээллийн технологи хичээлийн компьютер бүлэг сэдвийг судалж мэдсэн гарын товчлуурын үүрэг, хэрэглэх арга, программ дуудах, файл хадгалах зэрэг өмнөх суурь мэдлэг төсөөлөл, чадвар, суралцах технологийн орчин ямар байгааг илэрүүлэх зорилгоор оношлох үнэлгээг хийнэ гэж үзсэн.

Дөрөв. Анхаарах зүйл, санамж

Энэхүү “Суурь боловсролын мэдээллийн технологи хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэгжүүлэх зөвлөмж”-ийн өмнөх гурван бүлэгт 6-р ангийн “Баримт бичиг боловсруулах технологи” сэдвээр жишээлэн хөтөлбөрийн суралцахуйн зорилт, суралцахуйн үр дүн, үр дүнг үнэлэх шалгуурын холбоо хамаарал, хэрэгжүүлэх үйл явцыг бүрэн харуулахад төвлөрч, ерөнхий байдлаар байж болох нэгж, ээлжит хичээлийн үнэлгээний нэгэн хувилбарыг санал болгосон болно.

ЕБС-ын “Суралцагчийн үнэлгээ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүнг тодорхойлсон “шалгуур”-т суурилсан байна”³ гэж үзээд энд зөвхөн **шалгуурт суурилсан үнэлгээ хийх арга зүйг** товчхон жишээгээр авч үзлээ. Иймд мэдээллийн технологи хичээлээр сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэгжүүлэхдээ дараах зүйлийг анхаарч үнэлгээг хийх шаардлагатай.


1. Сургалтын үр дүнг үнэлэх СҮД шалгуур бүрийн хувьд гүйцэтгэлийн түвшинчилсэн шалгуурыг тодорхойлохдоо эзэмшсэн байх мэдлэг чадвар, түүний хэрэглээг ялгаж тодорхойлсон байгааг анхаарах.

Хүснэгт 12. СҮД, СҮД-ийн шалгуур

Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Шалгуурын ялгаа
Сурагч бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар хурдан, алдаагүй оруулж чаддаг болно.	6.3.1 Бичвэр мэдээллийн бүрэлдүүлэгч хэсгүүдийг ялган тайлбарладаг	Мэдлэг, ойлголтын шалгуур
	6.3.2 Компьютерт гарын хурууны зөв байрлалаар бичих технологийг тайлбарладаг.	Мэдлэг, ойлголтын шалгуур
	6.3.3 Компьютерт бичвэр мэдээллийг гарын хурууны зөв байрлалаар оруулдаг.	Чадвар (хэрэглээ)-ын шалгуур
Сурагч бичвэр мэдээллийг хэлбэржүүлэлт, мөр зэрэгцүүлэлт хийх замаар баримт бичгийн шаардлагад нийцүүлэн боловсруулж чаддаг болно.	6.3.4 Бичвэр мэдээллийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх үйлдлийг тайлбарладаг.	Мэдлэг, ойлголтын шалгуур
	6.3.5 Бичвэр мэдээллийг боловсруулахдаа хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх командыг гүйцэтгэдэг.	Чадвар (хэрэглээ)-ын шалгуур

³ БҮТ, 2018, “Ерөнхий боловсролын суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмыг хэрэгжүүлэх зөвлөмж”

2. Гүйцэтгэлийн түвшинчилсэн шалгуурт хийх үйлийг Блумын таксономын танин мэдэхүйн түвшнийг илэрхийлсэн үйл үгээр тодорхойлсон. Мэдээллийн технологийн шалгуурт ихэвчлэн сонгож хэрэглэсэн “тайлбарлах, гүйцэтгэх, боловсруулах” гэсэн үгүүд ямар өргөн утга илэрхийлж байгааг анхаарч даалгавар боловсруулах (Боловсролын үнэлгээний төв, 2020 он, “Боловсролын үнэлгээ, арга зүйн зөвлөмж”, хуудас 28-29 үзэх)
3. Зарим нэгж сэдвийн хувьд СҮД-ийн шалгуур нь маш ерөнхий тодорхойлогдсон. Иймд нэгжийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар, хэрэглээг нарийвчлан бүрэн гүйцэд тодорхойлж, үнэлгээний даалгавар боловсруулах (Боловсролын үнэлгээний төв, 2020 он, “Боловсролын үнэлгээ, арга зүйн зөвлөмж”, хуудас 25-27 үзэх)
4. Энэхүү зөвлөмжид нэгж сэдвийн үнэлгээ хийх төлөвлөлт хийхдээ хөтөлбөрийн үнэлгээний 3 зорилтыг (Мэдлэг ойлголт, чадвар, хандлага төлөвшил) тусгаж төлөвлөсөн ч хандлага төлөвшлийг хэрхэн үнэлэх талаар зөвлөмж оруулаагүй. Иймд хандлага төлөвшлийн үнэлгээг орхигдуулахгүй хийхэд анхаарах
(Боловсролын үнэлгээний төв, 2018 он, “Ерөнхий боловсролын суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмыг хэрэгжүүлэх зөвлөмж”, хуудас 16-19 үзэх)
5. Зөвлөмжид авсан жишиг даалгаврыг сэдвийн агуулга, СҮД-ийн үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийг хэмжих арга зүйг харуулах зорилгоор зохиосон тул үнэлгээний даалгаварт тавигдах шаардлагыг хангасан сайн жишиг даалгавар биш байх талтай. Иймд үнэлгээний даалгавар боловсруулах арга зүйг нарийвчлан судалж сайн даалгавар боловсруулах, даалгаврын оноожуулалтад анхаарах (Боловсролын үнэлгээний төв, 2020 он, “Боловсролын үнэлгээ, арга зүйн зөвлөмж”, хуудас 23-48 үзэх)
6. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх, гарсан үр дүнг хэрэглэх талаар нэмж судалж, хэрэгжүүлэх (Боловсролын үнэлгээний төв, 2020 он, “Боловсролын үнэлгээ, арга зүйн зөвлөмж”, хуудас 59-79 үзэх)
7. Энэхүү зөвлөмжид үнэлгээний шалгуурыг нэгжийн, ээлжит хичээлийн хувьд хэрхэн хэрэглэх жишээнд суурилан авч үзсэн. Үүнтэй адилаар бусад нэгж, ээлжит хичээлийн үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх боломжтой. Харин мэдээллийн технологийн хичээлийн жилийн үр дүнг тооцохдоо анги тус бүрийн хувьд “Сурагчийн хүрэх суралцахуйн үр дүн” 4-д баримжаалж үнэлгээний даалгавар боловсруулан жилийн эцсийн үнэлгээг хийх боломжтой.



⁴ “Мэдээллийн технологийн хичээлийн сурагчийн суралцахуйн үр дүн”, суурь боловсролын түвшин баримт бичгээс үзэх

ЕБС-ийн Мэдээллийн технологи хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

Б.Золзаяа МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхмийн ахлах багш, магистр
Э.Оюунбилэг 73 дугаар сургуулийн мэдээллийн технологийн багш, магистр

Хөндлөнгийн шинжээч:

Б.Баяржаргал МУИС, ШУС-ийн Математикийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Техникийн редактор:

Д.Энхжаргал Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр
Ш.Сувдмаа Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 3 х.х



Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-майл: info@eec.mn Вэб: www.eec.mn